



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/34

Улаанбаатар хот

Ёс зүйн дэд хороо байгуулах тухай

Монгол Улсын Их хурлын 2023 оны “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай” хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 дахь хэсэг, Ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолоор батлагдсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ын 1.4, 2.1, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн дүрмийн 5.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг 5 гишүүнтэй байхаар тогтоож, хүрээлэнгийн албан хаагчдын санал хураалтын дүнг үндэслэн Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.
2. Дэд хорооны даргыг хорооны хурлаар хэлэлцэж, сонгохыг дэд хорооны гишүүдэд даалгасугай.
3. Албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээллийг хуульд заасан харьяаллын дагуу шалган шийдвэрлэж, ажлын тайлан, мэдээг холбогдох газарт хүргүүлж байхыг Ёс зүйн дэд хороонд үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс /Б.Баатарцогт/-т даалгасугай.
5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2021 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирлын А/42 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ



Х.ЭРДЭМ-УНДРАХ

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирлын
2024 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн
А/34 тоот тушаалын хавсралт



Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн

М.Түвшинжаргал

Эрдэмтэн нарийн бичгийн дарга

С.Билигсайхан

Цахим мэдээлэл, олон нийттэй харилцах төвийн дарга

Ч.Халиун

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сангийн хянагч

Ц.Номин

Хүний нөөцийн мэргэжилтэн

Г.Мөнхсүвд

Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн